



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

**Сүлжээний дугаарлалтыг
хэсэгчлэн буцаан авах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ондо” ХХК-ийн 2024 оны 24/44 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо болон “Ондо” ХХК-ийн хооронд байгуулсан 2022 оны 31500013 тоот “Ондо ХХК-д олгосон сүлжээний дугаарлалтын гэрээ”-ний хавсралтаар олгогдсон сүлжээний дугаарын багцаас “81-11-xxxx”, “81-66-xxxx” “81-88-xxxx”, нийт 30,000 дугаарыг буцаан авсугай.
2. Сүлжээний дугаарлалтыг буцаан авсан тогтоол гарснаас өмнөх дугаарын төлбөрийн тооцоо нийлсэн акт үйлдэхийг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2022 оны 31500013 тоот “Ондо ХХК-д олгосон сүлжээний дугаарлалтын гэрээ”-ний хавсралтад холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР